

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2023/89/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2023 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.02.25 № 90

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА
С.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн Орон нутгийн өмчийн газрын №262 дугаар албан бичгээр 89,750.00 мянган төгрөгийн Ланд крузер J76 автомашин, 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/728 дугаар бүхий Засаг даргын захирамжаар 103,000.00 мянган төгрөгийн Ланд крузер 200 маркийн автомашин хөрөнгийн дансанд орлогдсон байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр 41-н төсөл хөтөлбөрийг 958,693.40 мянган төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 708,076.50 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй, 250,616.90 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Төсөл хөтөлбөрийн хэрэгжилт 77.41 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Орхон аймгийн Засаг даргын “Үндсэн хөрөнгө актлах, худалдах, шилжүүлэх тухай” захирамжийн дагуу 1,858.00 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, “Хөрөнгө шилжүүлэх тухай” захирамжийн дагуу 89,500.00 мянган төгрөгийн (2ш тээврийн хэрэгсэл) балансын өртөг бүхий хөрөнгө, 144,920.0 мянган төгрөгийн аж ахуйн зориулалтай газрыг орон нутагт шилжүүлсэн ба нийт 236,278.00 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус актлан, данснаас хасалт хийсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>69,804,938.86</u>	<u>222,177,240.36</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	69,804,938.86	222,177,240.36
351	Түүхий эд материал	58,951,617.85	205,802,005.35
35110	Тусгай зориулалттай материал	58,951,617.85	205,802,005.35
354	Хангамжийн материал	10,853,321.01	16,375,235.01
35410	Бичиг хэргийн материал	243,800.00	00.00
35430	Сэлбэг хэрэгсэл	300,000.00	300,000.00
35440	Түлш, шатах тослох материал	6,541,286.01	5,785,000.01
35470	Бусад хангамжийн материал	3,768,235.00	10,290,235.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>482,837,073.90</u>	<u>562,675,065.43</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	482,837,073.90	562,675,065.43
392	Биет хөрөнгө	334,750,407.36	511,628,398.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	74,384,726.49	74,384,726.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	-11,041,611.84	-14,722,149.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	95,627,560.00	197,019,560.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-73,562,282.00	-15,856,365.58
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	102,300,263.19	106,683,200.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-63,367,021.52	-33,919,558.29
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,656,978.72	40,553,488.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-46,271,428.74	-23,066,914.02
39214	Бусад үндсэн хөрөнгө	247,549,480.37	253,549,480.37
39215	Хуримтлагдсан элэгдэл	-49,526,257.31	-72,997,068.92
393	Биет бус хөрөнгө	148,086,666.54	51,046,666.50
39301	Программ хангамж	21,195,000.00	21,195,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-19,948,333.46	-20,628,333.50
39303	Бусад биет бус хөрөнгө	146,840,000.00	50,480,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>552,642,012.76</u>	<u>784,852,305.79</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>552,642,012.76</u>	<u>784,852,305.79</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	552,642,012.76	784,852,305.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	258,066,475.95	258,066,475.95
51101	Өмч: - төрийн	258,066,475.95	258,066,475.95
512	Хуримтлагдсан үр дүн	287,867,148.93	520,567,874.96
51210	Өмнөх үеийн үр дүн	287,867,148.93	288,357,581.93
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	232,210,293.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,708,387.88	6,217,954.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>552,642,012.76</u>	<u>784,852,305.79</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	996,827,097.00	1,598,005,200.00

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	118,181,997.00	397,975,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	61,060,860.00	397,975,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	61,060,860.00	100,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000.00	100,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	61,010,860.00	00.00
121	Хөрөнгийн орлого	57,121,137.00	00.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	57,121,137.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	878,645,100.00	1,200,030,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	646,550,000.00	958,693,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	645,550,000.00	958,693,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	232,095,100.00	241,336,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	232,095,100.00	241,336,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,064,918,376.21	1,248,948,795.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,064,918,376.21	1,248,948,795.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	964,043,593.46	995,234,125.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	199,100,313.74	229,475,096.54
210101	Үндсэн цалин	127,227,244.00	130,743,135.00
210102	Нэмэгдэл	45,705,140.00	42,327,061.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,677,455.00	13,200,300.00
210104	Урамшуулал	18,490,474.74	43,204,600.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,965,034.45	28,369,275.78
210201	Тэтгэврийн даатгал	18,012,979.52	19,467,307.76
210202	Тэтгэмжийн даатгал	1,968,719.47	2,141,696.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,602,655.62	1,832,237.70
210204	Ажилгүйдлийн даатгал	388,807.13	425,987.78
210205	Эрүүл мэндийн даатгал	3,991,872.71	4,502,045.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,198,000.44	4,229,013.00
210301	Гэрэл, цахилгаан	1,652,128.44	1,678,040.00
210302	Түлш, халаалт	1,395,872.00	836,593.00
210303	Цэвэр, бохир ус	3,150,000.00	1,714,380.00
2104	Хангамж, бараа материалын зардал	55,497,680.54	86,833,006.00
210401	Бичиг хэрэг	1,131,500.00	2,242,800.00
210402	Тээвэр, шатахуун	52,367,297.92	81,107,286.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,297,882.62	1,462,920.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	101,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	1,720,000.00
2105	Нормативт зардал	17,294,600.00	8,750,000.00
210502	Хоол, хүнс	7,995,600.00	8,750,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,299,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,781,312.95	2,140,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,721,312.95	80,000.00

210604	Урсгал засвар	2,060,000.00	2,060,000.00
2107	Томилолт, зочны зардал	700,100.00	5,370,000.00
210702	Дотоод албан томилолт	700,100.00	5,370,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	570,858,041.00	575,260,836.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	568,457,596.00	573,029,936.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	990,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	213,840.00	222,750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	192,405.00	298,695.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	473,000.00	323,000.00
210807	Газрын төлбөр	757,200.00	330,455.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,648,510.34	54,806,897.31
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	720,000.00	01.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,928,510.34	54,806,897.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,874,782.75	253,714,670.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,150,000.00	3,089,250.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,150,000.00	3,089,250.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	91,724,782.75	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,033,348.66	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	250,625,420.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-68,091,279.21	349,056,404.19
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	20,486,111.16
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	20,486,111.16
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-20,486,111.16
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-68,091,279.21	328,570,293.03

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	970,448,429.00	1,200,130,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,000.00	100,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	50,000.00	100,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,000.00	100,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000.00	100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	970,398,429.00	1,200,030,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	738,303,329.00	958,693,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	737,303,329.00	958,693,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	232,095,100.00	241,336,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	232,095,100.00	241,336,700.00

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	970,448,429.00	1,194,130,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	970,448,429.00	1,194,130,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	869,573,646.25	940,415,429.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	199,006,687.74	229,475,096.54
210101	Үндсэн цалин	127,227,244.00	130,743,135.00
210102	Нэмэгдэл	45,705,140.00	42,327,061.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,677,455.00	13,200,300.00
210104	Урамшуулал	18,396,848.74	43,204,600.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,965,034.45	28,369,275.78
210201	Тэтгэврийн даатгал	18,012,979.52	19,467,307.76
210202	Тэтгэмжийн даатгал	1,968,719.47	2,141,696.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,602,655.62	1,832,237.70
210204	Ажилгүйдлийн даатгал	388,807.13	425,987.78
210205	Эрүүл мэндийн даатгал	3,991,872.71	4,502,045.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,198,000.44	4,229,013.00
210301	Гэрэл, цахилгаан	1,652,128.44	1,678,040.00
210302	Түлш, халаалт	1,395,872.00	836,593.00
210303	Цэвэр, бохир ус	3,150,000.00	1,714,380.00
2104	Хангамж, бараа материалын зардал	55,462,182.62	83,922,320.00
210401	Бичиг хэрэг	1,375,300.00	1,999,000.00
210402	Тээвэр, шатахуун	52,088,000.00	78,440,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,297,882.62	1,462,920.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	101,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	1,720,000.00
2105	Нормативт зардал	7,995,600.00	8,750,000.00
210502	Хоол, хүнс	7,995,600.00	8,750,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,255,000.00	2,360,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	195,000.00	300,000.00
210604	Урсгал засвар	2,060,000.00	2,060,000.00
2107	Томилолт, зочны зардал	700,100.00	5,370,000.00
210702	Дотоод албан томилолт	700,100.00	5,370,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	571,271,041.00	577,939,724.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	568,870,596.00	575,708,824.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	990,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	213,840.00	222,750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	192,405.00	298,695.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	473,000.00	323,000.00
210807	Газрын төлбөр	757,200.00	330,455.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	720,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	720,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,874,782.75	253,714,670.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,150,000.00	3,089,250.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,150,000.00	3,089,250.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	250,625,420.68
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	91,724,782.75	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,033,348.66	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	6,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	6,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	6,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	6,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	6,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-6,000,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	258,066,475.95	2,171,225.00	148,766,721.30	409,004,422.25
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	258,066,475.95	2,171,225.00	148,766,721.30	409,004,422.25
7	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	154,320,403.80	154,320,403.80
8	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	258,066,475.95	6,708,387.88	287,867,148.93	552,642,012.76
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	258,066,475.95	6,708,387.88	287,867,148.93	552,642,012.76
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	490,433.00	490,433.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	258,066,475.95	6,708,387.88	288,357,581.93	553,132,445.76
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-490,433.00	00.00	-490,433.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-96,360,000.00	00.00	00.00	-96,360,000.00
8	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	328,570,293.03	328,570,293.03
9	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	161,706,475.95	6,217,954.88	616,927,874.96	784,852,305.79

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	242,836,700.00	241,428,226.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	242,836,700.00	241,428,226.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	239,746,700.00	238,338,976.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	194,302,400.00	193,555,606.60
210101	Үндсэн цалин	130,818,600.00	130,743,135.00
210102	Нэмэгдэл	42,510,800.00	42,327,061.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,279,000.00	13,200,300.00
210104	Урамшуулал	7,694,000.00	7,285,110.60
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,640,200.00	24,541,536.48

210201	Тэтгэврийн даатгал	16,755,300.00	16,688,310.56
210202	Тэтгэмжийн даатгал	1,971,200.00	1,963,206.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,577,000.00	1,570,685.00
210204	Ажилгүйдлийн даатгал	394,300.00	392,520.48
210205	Эрүүл мэндийн даатгал	3,942,400.00	3,926,813.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,501,000.00	4,229,013.00
210301	Гэрэл, цахилгаан	1,750,000.00	1,678,040.00
210302	Түлш, халаалт	891,000.00	836,593.00
210303	Цэвэр, бохир ус	1,860,000.00	1,714,380.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,339,000.00	8,301,920.00
210401	Бичиг хэрэг	1,999,000.00	1,999,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,820,000.00	2,820,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,462,920.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,720,000.00	1,720,000.00
2105	Нормативт зардал	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,460,000.00	2,360,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	400,000.00	300,000.00
210604	Урсгал засвар	2,060,000.00	2,060,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,970,000.00	1,970,000.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	1,970,000.00	1,970,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,534,100.00	3,380,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,300,000.00	1,150,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	990,000.00	990,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	223,000.00	222,750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	299,600.00	298,695.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	325,000.00	323,000.00
210807	Газрын төлбөр	330,500.00	330,455.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,090,000.00	3,089,250.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,090,000.00	3,089,250.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,090,000.00	3,089,250.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	242,836,700.00	241,428,226.08
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	0.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	241,336,700.00	241,328,226.08
320001	Орон нутгийн төсвөөс	241,336,700.00	241,328,226.08
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,500,000.00	100,000.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	100,000.00

2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	958,693,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	952,693,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	702,076,453.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35,919,489.94
210101	Үндсэн цалин	35,919,489.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,827,739.30
210201	Тэтгэврийн даатгал	2,778,997.20
210202	Тэтгэмжийн даатгал	178,490.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	261,552.70
210204	Ажилгүйдлийн даатгал	33,467.30
210205	Эрүүл мэндийн даатгал	575,231.80
2104	Хангамж, бараа материалын зардал	75,620,400.00
210402	Тээвэр, шатахуун	75,620,400.00
2105	Нормативт зардал	8,750,000.00
210502	Хоол, хүнс	8,750,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,400,000.00
210702	Дотоод албан томилолт	3,400,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	574,558,824.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	574,558,824.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	250,616,946.76
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	250,616,946.76
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	250,616,946.76
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	958,693,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	958,693,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	958,693,400.00

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,126.57 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 193.70 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 5,785.00 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 147.87 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

1. Төлбөрийн акт

Томилолтын зардалд цахим төлбөрийн баримтгүй 193.7 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Татварын ерөнхий хуулийн 28.5-д "дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Албан шаардлага

Шатахууны эхний үлдэгдэл 6.541.2 мянган төгрөг, тайлангийн хугацаанд 80,391.0 мянган төгрөгийн шатахууныг төсөвлөн авч, 81,107.2 мянган төгрөгийн шатахууныг зарцуулан, 5,785.0 мянган төгрөгийн шатахууны үлдэгдэлтэй байгаа нь буцаан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгөөр бараа материалын нөөц үүсгэн, үлдэгдлээр тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3.-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасныг зөрчсөн байна.

3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалинг тооцохдоо НДШ-ийг илүү дутуу тооцож дараа сард залруулахдаа 147.8 мянган төгрөгөөр илүү тайлагнаж, цалингийн хүснэгт болон нийгмийн даатгалын тайлангийн шимтгэлийн дүнг зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилчдын цалинг бодохдоо үнэн зөв тооцож, суутгах татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг үнэн зөв, заавар журмын дагуу бодож, тайлагнах.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төсвийн хуваарьт батлагдаагүй 60,000.0 мянган төгрөгөөр аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1-д "Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно", 33.1-д "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно" гэсэн хэсэг, ЗГ-ын 2021 оны 124 дүгээр "Босго үнэ шинэчлэн батлах тухай" тогтоолтой тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгөөс хамааруулан сонгон шалгаруулалтыг хууль, журмын дагуу зохион байгуулах

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		
Цахим төлбөрийн баримтгүй томилолтын зардлын унааны баримтыг хувь хүний сугалаатай баримтаар гүйлгээ хийсэн байна.	1	193.70	1	193.70								
Сарын цалинг тооцохдоо НДШ-ийг илүү дутуу тооцож дараа сард залруулж тайлагнахдаа илүү тайлагнаж цалингийн хүснэгт болон нийгмийн даатгалын тайлангийн шимтгэлийн дүн зөрүүтэй тайлагнасан.	1	147.87					1	147.87				
2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төсвийн хуваарьт батлагдаагүй аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлийн ажлыг зохион байгуулахдаа Аймгийн засаг даргын А/887 дугаар захирамжаар хийсэн боловч уг ажлыг хийж гүйцэтгэхдээ харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалтыг хийгээгүй байна.	1	0.0					1	0.0				
Шатахууны үлдэгдэлтэй байгаа нь бараа материалын нөөц үүсгэн үлдэгдлээр тайлагнасан байна.	1	5,785.00			1	5,785.00		-				
Дүн	4	6,126.57	1	193.70	1	5,785.00	2	147.87				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилгүй.									

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитаар хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			